

2026 ОНЫ 8 ДУГААР САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН САМБАРЫН СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Д. Баярмаа¹

Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага бүхий Үндэсний MNS 7023 2023 стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023.12.01-ний өдрийн С/49 дүгээр тушаалаар баталсан. Энэхүү стандартыг улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч этгээд 2024.04.01-нээс мөрдөх үүрэгтэй. Энэ хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг иргэдэд таниулах зорилготой мэдээлэл бүхий зурган самбарыг байршуулах ёстой юм. Түүнчлэн мэдээллийн самбарын зургийг publicinvestment.gov.mn цахим хуудаст нийтлэх юм. Энэхүү судалгаа нь улс, нийслэлийн төсөв ба төрийн өмчит компани (ТӨК)-ийн санхүүжилттэй хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэгч нь мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн эсэхийг publicinvestment.gov.mn цахим хуудаст самбарын зургаа нийтэлсэн байдал дээр үндэслэн судалж, тодорхойлох зорилготой. Хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэгч нь мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн эсэхэд дүн шинжилгээ хийж, дүнг нийтэд хүргэх, хэлэлцүүлэг өрнүүлэх нь төсвийн зарцуулалтыг иргэд мэдэх эрхийг хангах, хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтэд хяналт тавих, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм.

УЛС, ОРОН НУТАГ, ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН МЭДЭЭЛЛИЙН САМБАРЫН ҮНДЭСНИЙ MNS 7023 2023 СТАНДАРТЫН ТУХАЙ

Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч этгээд тухайн төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг иргэдэд таниулах зорилготой мэдээлэл бүхий зурган самбарыг байршуулах үүрэгтэй. Үндэсний

MNS 7023:2023 стандартын дагуу дараах 11 төрлийн мэдээллийг самбарт тусгахаар баталсан байна. Үүнд:

1. Ажлын нэр;
2. Хөрөнгийн эх үүсвэр;
3. Хүчин чадал;
4. Захиалагч байгууллагын нэр, утасны дугаар;
5. Гүйцэтгэгч байгууллагын нэр, утасны дугаар;

¹ Талархал: Энэхүү дүн шинжилгээг сайжруулах зорилгоор үнэтэй санал, шүүмж өгсөн Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадамд болон хөрөнгө оруулалтын төслүүдийн мэдээлэл өгсөн Авлигатай тэмцэх газар, Сангийн яаманд талархал илэрхийлж байна.

6. Талбайн инженерийн нэр, утасны дугаар;
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны нэр, утасны дугаар;
8. Гэрээний үнийн дүн;
9. Ажил эхлэх, дуусах хугацаа;
10. Төсөл хэрэгжиж бий болох загвар зураг 3D;
11. Бүтээн байгуулалтын загвар зураг.

Түүнчлэн самбарын үсгийн өнгө цагаан байх, мэдээлэл монгол хэл дээр байх, самбарын тулгуур нь металл багана байх, самбарыг байршуулсан байх гэсэн шаардлага тавигддаг. Цаашилбал, самбарт бүрэн хэмжээний загвар,

барилгын ажлын зураг, төслийн орчны тойм зургийг том масштабаар үзүүлэх ба төслийн дэлгэрэнгүй мэдээллийг А4 буюу 21х29.7см хэмжээтэй QR кодыг ашиглан электрон байдлаар хэрэглэгчдэд хүргэхээр самбарт нэмж тусгахаар стандартад заажээ.

Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжийн санхүүжилттэй инженерийн барилга байгууламжийн барилгын ажлын болон гадна тохижилтын ажлын самбарын загварыг мөн стандартын хүрээнд гаргасан байна.

Зураг 1. Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжийн санхүүжилттэй инженерийн барилга байгууламжийн барилгын ажлын самбарын загвар



Зураг 2. Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжийн санхүүжилттэй гадна тохижилтын ажлын самбарын загвар



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЛИЙН БИЕТ САМБАРЫН ЗУРГИЙГ ЦАХИМ ХУУДАСТ НИЙТЭЛСЭН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан хөрөнгө оруулалтын 1011 төсөл, арга хэмжээний 41.7 хувь буюу 422 нь мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтлээгүй байна.

Сангийн яамнаас ирүүлсэн улс, нийслэлийн төсөв ба ТӨК-ийн санхүүжилттэй нийт 1061 төсөл, арга хэмжээний жагсаалтаас код, нэр давхацсан ижил төсөл, арга хэмжээнүүдийг хасажнийт 1011 төсөл, арга хэмжээ (улсын төсвийн санхүүжилттэй 680, ТӨК-ийн санхүүжилттэй 35, нийслэлийн төсвийн санхүүжилттэй 296)-ний мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийг publicinvestment.gov.mn

цахим хуудаст 2026 оны 6 дугаар сарын байдлаар самбарын зургаа нийтэлсэн байдал дээр үндэслэн шинжлэв. Эдгээр төсөл, арга хэмжээний 58.3 хувь буюу 589 төсөл, арга хэмжээ мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байна. Харин 41.7 хувь буюу 422 төсөл, арга хэмжээ мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтлээгүй байна. Эдгээр төсөл, арга хэмжээ

нь мэдээллийн самбарын хэвлэгдээгүй загвар зураг, эсвэл word, power point зэрэг программ дээр бэлтгэсэн төсөл, арга хэмжээний талаарх мэдээлэл, самбар дээр гараар бичсэн мэдээлэл, QR код, барилгын зураг, ажлын явцын зураг,

аюулгүй байдлын санамж, төсөв, тайлан, гэрээ, акт, албан бичгүүд зэрэг бусад төрлийн баримт, мэдээллийн зургийг цахим хуудаст нийтэлжээ (Хавсралт 1).


Зураг 3. Хөрөнгө оруулалтын төслийн мэдээллийн биет самбарын зургийн оронд мэдээллийн самбарын хэвлэгдээгүй загвар зураг ба бусад мэдээлэл байршуулсан төсөл, арга хэмжээнүүдийн жишээнээс



Цаг уурын өртөөний барилгын шинэчлэл (Булган, Сэлэнгэ, Ингэт толгой)



Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл (Сүхбаатар, Баруун-Урт сум)



Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц (Дундговь)



Буянт хотхон хүүхдийн зуслангийн өвлийн байр, 250 ор (Өмнөговь, Даланзадгад сум)



Боловсрол цогцолбор сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны гадна фасад засварын ажил (УБ хот, БНД, 3 дугаар хороо) Багц-2



Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат (Дорнод аймгийн Халхгол, Чулуунхороот, Чойбалсан сум)



Дөргөний хөв цөөрөм (Ховд, Дөргөн)



Зүүн бүсэд Ус, Цаг уур, Хамгаалалтын захиргааны харуулын байр барих (Дорнод, Сүхбаатар, Хэнтий)



Нийслэлийн Ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга (УБ хот, ХУД, 4-р хороо)

Барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээний 35.5 хувь, их засварын төсөл, арга хэмжээний 72.5 хувь нь мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтлээгүй байна.

Төсөл, арга хэмжээний төрлөөр авч үзвэл барилга, байгууламжийн 840 төсөл, арга хэмжээний 64.5 хувь буюу 542 нь мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн бол 35.5 хувь буюу 298

нь нийтлээгүй байна. Харин их засварын 171 төсөл, арга хэмжээний 27.5 хувь буюу 47 нь мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн бол 72.5 хувь буюу 124 нь нийтлээгүй байна.

Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдал (төрлөөр)

Төрөл	Төсөл, арга хэмжээний тоо	Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан		Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулаагүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Барилга байгууламж	840	542	64.5%	298	35.5%
Их засвар	171	47	27.5%	124	72.5%
Нийт	1011	589	58.3%	422	41.7%

Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлыг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл Монгол Улсын Шадар сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Эрчим хүчний сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд нарын гүйцэтгэл 70-аас дээш хувь байна. Харин Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын гүйцэтгэл 0 хувь байна.

Төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлын гүйцэтгэлийн хувийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл Монгол Улсын Шадар сайд 100 хувь, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга 100 хувь, Эрчим хүчний сайд 89.2 хувь, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд 74.7 хувь, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 73.7 хувь буюу харьцангуй сайн гүйцэтгэлтэй байна.

Зам, тээврийн сайд, Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Улсын Ерөнхий прокурор нарын гүйцэтгэл 50-63.4 хувь, Нийслэлийн Засаг

дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын гүйцэтгэл 31.6-46.6 хувь байна. Харин Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд нарын гүйцэтгэл 0 хувьтай байна.

Жишээлбэл, цахим ил тод байдлыг манлайлах үүрэгтэй Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд цахим хуудаст нийтэлбэл зохих нийт 17 төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг огт нийтлээгүй буюу гүйцэтгэлийн хувь 0 байна.

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний тоо	Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан		Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулаагүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Сангийн сайд	5	2	40.0%	3	60.0%
Хууль зүй, дотоод хэргийн сайд	17	6	35.3%	11	64.7%
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	19	6	31.6%	13	68.4%
Гадаад харилцааны сайд	1	0	0.0%	1	100.0%
Монгол Улсын Ерөнхий сайд	1	0	0.0%	1	100.0%
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	2	0	0.0%	2	100.0%
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	0	0.0%	1	100.0%
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	3	0	0.0%	3	100.0%
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	17	0	0.0%	17	100.0%
Нийт	1011	589	58.3%	422	41.7%


Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Аймгуудад хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлыг авч үзвэл Орхон, Баянхонгор, Дархан-Уул, Өвөрхангай, Дундговь аймгуудад байршилтай төслүүдийн гүйцэтгэл 80-аас дээш хувь байгаа бол Дорноговь аймагт 46.7 хувь буюу хамгийн бага гүйцэтгэлтэй байна.

Улсын төсөв ба ТӨК-ийн санхүүжилтээр аймгуудад хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлын гүйцэтгэлийн хувийг авч үзвэл Орхон, Баянхонгор, Дархан-Уул, Өвөрхангай, Дундговь аймгуудын гүйцэтгэл 80-аас дээш хувь буюу харьцангуй сайн гүйцэтгэлтэй байна. Увс, Өмнөговь,

Завхан аймгуудын гүйцэтгэл 70.5-76 хувь, Баян-Өлгий, Булган, Сүхбаатар, Хэнтий аймгуудын гүйцэтгэл 60-66.7 хувь, Төв, Говь-Алтай, Архангай, Ховд, Хөвсгөл, Дорнод, Сэлэнгэ аймгуудын гүйцэтгэл 50-59.4 хувь байна. Харин Дорноговь аймгийн гүйцэтгэл хамгийн бага буюу 46.7 хувь байна.

Зураг 5. Улсын төсөв, ТӨК-ийн санхүүжилтээр аймгуудад хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдал (гүйцэтгэлийн хувиар)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Хүснэгт 3. Улсын төсөв, ТӨК-ийн санхүүжилтээр аймгуудад хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдал

Аймаг	Төсөл, арга хэмжээний тоо	Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан		Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулаагүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Баян-Өлгий, Хөвсгөл, Хэнтий	1	1	100.0%	0	0.0%
Дархан-Уул, Сэлэнгэ	1	1	100.0%	0	0.0%
Орхон	4	4	100.0%	0	0.0%
Баянхонгор	21	18	85.7%	3	14.3%
Дархан-Уул	52	44	84.6%	8	15.4%
Өвөрхангай	45	38	84.4%	7	15.6%
Дундговь	15	12	80.0%	3	20.0%
Увс	25	19	76.0%	6	24.0%
Өмнөговь	4	3	75.0%	1	25.0%
Завхан	44	31	70.5%	13	29.5%
Баян-Өлгий	18	12	66.7%	6	33.3%
Булган	22	14	63.6%	8	36.4%
Сүхбаатар	33	21	63.6%	12	36.4%
Хэнтий	45	28	62.2%	17	37.8%

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Аймаг	Төсөл, арга хэмжээний тоо	Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан		Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулаагүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Говьсүмбэр	10	6	60.0%	4	40.0%
Төв	32	19	59.4%	13	40.6%
Говь-Алтай	17	10	58.8%	7	41.2%
Архангай	31	17	54.8%	14	45.2%
Ховд	45	26	57.8%	19	42.2%
Хөвсгөл	42	24	57.1%	18	42.9%
Дорнод	25	13	52.0%	12	48.0%
Сэлэнгэ	26	13	50.0%	13	50.0%
Дорноговь	15	7	46.7%	8	53.3%
Говь-Сүмбэр, Дорноговь, Дундговь (Гурван аймгийн хамтарсан төсөл)	1	0	0.0%	1	100.0%

Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Улсын төсвийн санхүүжилтээр бүсүүдэд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлыг авч үзвэл Баруун бүс, Хангайн бүс, Өмнөд бүс, Хойд бүсийн гүйцэтгэл 100 хувь байгаа бол Говийн бүс, Зүүн бүсийн гүйцэтгэл 33.3 хувьтай байна.

Бүсүүдэд улсын төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалтын нийт 20 төсөл хэрэгжиж байна. Улсын төсвөөр бүсүүдэд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлын гүйцэтгэлийн

хувийг авч үзвэл Баруун бүс, Хангайн бүс, Өмнөд бүс, Хойд бүсийн гүйцэтгэл 100 хувь, Төвийн бүсийн гүйцэтгэл 75 хувь, Говийн бүс, Зүүн бүсийн гүйцэтгэл 33.3 хувь байна.

Хүснэгт 4. Улсын төсвөөр бүсүүдэд хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдал

Бүс	Төсөл, арга хэмжээний тоо	Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан		Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулаагүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Баруун бүс	3	3	100.0%	0	0.0%
Хангайн бүс	1	1	100.0%	0	0.0%
Өмнөд бүс	1	1	100.0%	0	0.0%
Хойд бүс	1	1	100.0%	0	0.0%
Төвийн бүс	8	6	75.0%	2	25.0%
Говийн бүс	3	1	33.3%	2	66.7%
Зүүн бүс	3	1	33.3%	2	66.7%
Улсын хэмжээнд	2	0	0.0%	2	100.0%


Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Улс ба нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлыг дүүргүүдээр авч үзвэл Багануур дүүрэгт байршилтай төслүүдийнх хамгийн өндөр буюу 64.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол Багахангай дүүрэгт байршилтай төслүүдийнх 25 хувь буюу хамгийн муу гүйцэтгэлтэй байна.

Улс ба нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлын гүйцэтгэлийн хувийг дүүргүүдээр авч үзвэл нийслэлийн дүүргүүдийн хувьд Багануур дүүрэгт байршилтай төслүүдийн гүйцэтгэл хамгийн өндөр буюу 64.7 хувь

байна. Хан-Уул, Баянгол, Налайх дүүргүүдийн гүйцэтгэл 50-54.8 хувь, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргүүдийн гүйцэтгэл 40.7-48.1 хувь, Чингэлтэй дүүргийн гүйцэтгэл 30.6 хувь байна. Багахангай дүүргийн гүйцэтгэл хамгийн бага буюу 25 хувь байна.

Зураг 6. Улс ба нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдал (гүйцэтгэлийн хувиар)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Хүснэгт 5. Улс ба нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдал

Дүүрэг	Төсөл, арга хэмжээний тоо	Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан		Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулаагүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Багануур дүүрэг	17	11	64.7%	6	35.3%
Хан-Уул дүүрэг	42	23	54.8%	19	45.2%
Баянгол дүүрэг	63	34	54.0%	29	46.0%
Налайх дүүрэг	6	3	50.0%	3	50.0%
Нийслэл	79	38	48.1%	41	51.9%
Баянзүрх дүүрэг	59	27	45.8%	32	54.2%
Сүхбаатар дүүрэг	51	23	45.1%	28	54.9%
Сонгинохайрхан дүүрэг	54	22	40.7%	32	59.3%
Чингэлтэй дүүрэг	36	11	30.6%	25	69.4%
Багахангай дүүрэг	8	2	25.0%	6	75.0%

Эх сурвалж: publicinvestment.gov.mn

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЛИЙН БИЕТ САМБАРЫН ЗУРГИЙГ ЦАХИМ ХУУДАСТ НИЙТЭЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД МЭДЭЭЛЛИЙН САМБАРЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн 589 төсөл, арга хэмжээний хувьд самбарын тулгуур нь металл багана байх, үсгийн өнгө цагаан байх, хүчин чадал ба гэрээний үнийн дүнг тусгах гэсэн стандартуудын хэрэгжилт харьцангуй сул байна.

Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн улс, нийслэлийн төсвийн санхүүжилттэй 589 төсөл, арга хэмжээний хувьд мэдээллийн самбар нь Үндэсний MNS 7023 2023 стандартыг хэрхэн хэрэгжүүлсэн байдлыг хянав. Энэ хүрээнд цахим хуудаст нийтэлсэн зурагт үндэслэн тодорхойлох боломжтой 15 стандартын гол шаардлагуудыг хангасан эсэхийг хяналаа. Үүнд, тухайн мэдээллийн самбарт заавал тусгах ёстой мэдээллүүд буюу 1. Ажлын нэр, 2. Хөрөнгийн эх үүсвэр, 3. Хүчин чадал, 4. Захиалагч байгууллагын нэр, утасны дугаар, 5. Гүйцэтгэгч байгууллагын

нэр, утасны дугаар, 6. Талбайн инженерийн нэр, утасны дугаар, 7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны нэр, утасны дугаар, 8. Гэрээний үнийн дүн, 9. Ажил эхлэх, дуусах хугацаа, 10. Төсөл хэрэгжиж бий болох загвар зураг 3D/Бүтээн байгуулалтын загвар зураг байгаа эсэх агуулгын шаардлагаас гадна самбарын дэвсгэр өнгө цэнхэр байх, үсгийн өнгө цагаан байх, самбарын мэдээлэл монгол хэл дээр байх, самбарын тулгуур нь металл багана байх, самбарыг байршуулсан байх гэсэн шаардлагуудыг цахим хуудаст нийтэлсэн зурагт үндэслэн нягтлав.

Самбарын материал нь байгалийн үзэгдэлд тэсвэрлэхүйц зэвэрдэггүй, гандахгүй, шөнийн цагт саадгүй харагдах гэрлийн ойлтын тусгалтай байх, самбарын бичвэр нь ирмэгээс дотогш тус бүр 20 см-ийн зайтай бичигдэх, үсгийн бичвэр Roboto Condensed Bold фонтоор, үсгийн хэмжээ гарчигт 210 pt, бусад бичвэрүүд 140 pt хэмжээтэй байх, нэрийн бичвэр, тэмдэгтийн тоо, төсөл арга хэмжээнээс хамаарч самбарын хэмжээ нь 1.5 м х 2.2 м-ээс багагүй байх гэсэн стандартын шаардлагуудыг зургаас харж тодорхойлох боломжгүй байв. Мөн зургийн чанар, хэмжээнээс шалтгаалж зарим стандартын хэрэгжилтийг зургаас харж тодорхойлох боломжгүй байлаа.

Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн 589 төсөл, арга хэмжээний хувьд:


1. Ажлын нэрийг 92.5 хувь буюу 545 нь тусгажээ. 7.5 хувь буюу 44 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
2. Хөрөнгийн эх үүсвэрийг 67.6 хувь буюу 398 нь тусгаж, 22.2 хувь буюу 131 нь тусгаагүй байна. 10.2 хувь буюу 60 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
3. Хүчин чадлыг 58.4 хувь буюу 344 нь тусгаж, 31.4 хувь буюу 185 нь тусгаагүй байна. 10.2 хувь буюу 60 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
4. Захиалагч байгууллагын нэр, утасны дугаарыг 0.8 хувь буюу 5 нь бүрэн тусгаж, 86.6 хувь буюу 510 нь зөвхөн захиалагч байгууллагын нэрийг тусгасан байна. 3.1 хувь буюу 18 нь огт тусгаагүй, 9.5 хувь буюу 56 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
5. Гүйцэтгэгч байгууллагын нэр, утасны дугаарыг 3.7 буюу 22 нь мэдээллийн самбарт бүрэн тусгаж, 84.9 хувь буюу 500 нь зөвхөн гүйцэтгэгч байгууллагын нэрийг тусгасан байна. 1.9 буюу 11 нь огт тусгаагүй, 9.5 хувь буюу 56 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
6. Талбайн инженерийн нэр, утасны дугаарыг 67.6 хувь буюу 398 нь бүрэн тусгаж, 1.9 хувь буюу 11 нь зөвхөн нэр, утасны дугаарын аль нэгийг тусгасан байна. 20.9 хувь буюу 123 нь огт тусгаагүй. 9.7 буюу 57 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны нэр, утасны дугаарыг 58.2 хувь буюу 343 нь бүрэн тусгаж, 2.5 хувь буюу 15 нь нэр, утасны дугаарыг аль нэгийг тусгасан байна. 29.5 хувь буюу 174 нь огт тусгаагүй, 9.7 хувь буюу 57 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
8. Гэрээний үнийн дүнг 54.2 хувь буюу 319 нь тусгаж, 35.5 хувь буюу 209 нь тусгаагүй байна. 10.4 хувь буюу 61 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
9. Ажил эхлэх, дуусах хугацааг 81.7 хувь буюу 481 нь тусгаж, 8.1 хувь буюу 48 нь тусгаагүй байна. 10.2 хувь буюу 60 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
10. Төсөл хэрэгжиж бий болох загвар зураг 3D/Бүтээн байгуулалтын загвар зургийг аль нэгийг 95.4 хувь буюу 562 нь тусгаж, 3.7 хувь буюу 22 нь тусгаагүй байна. 0.8 хувь буюу 5 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
11. Дэвсгэр өнгө цэнхэр байх стандартын шаардлагыг 70.6 хувь буюу 416 нь хэрэгжүүлж, 29.4 хувь буюу 173 нь хэрэгжүүлээгүй байна.
12. Үсгийн өнгө цагаан байх стандартын шаардлагыг 62.8 хувь буюу 370 нь хэрэгжүүлж, 37.2 хувь буюу 219 нь хэрэгжүүлээгүй байна.
13. Самбарын мэдээлэл монгол хэл дээр байх стандартын шаардлагыг 99.3 хувь буюу 585 нь хэрэгжүүлжээ. 0.7 хувь буюу 4 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
14. Самбарын тулгуур нь металл багана байх стандартын шаардлагыг 35.8 хувь буюу 211 нь хэрэгжүүлж, 49.9 хувь буюу 294 нь хэрэгжүүлээгүй байна. 14.3 хувь буюу 84 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.
15. Самбарыг байршуулсан байх стандартын шаардлагыг 92.7 хувь буюу 546 нь хэрэгжүүлжээ. 7.3 хувь буюу 43 нь зургаас харж тодорхойлох боломжгүй байна.

Зураг 7. Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (стандартыг бүрэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хувийн жин, стандартын шаардлага тус бүрээр)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Зураг 8. Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (стандартыг хэсэгчлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хувийн жин, стандартын шаардлага тус бүрээр)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Зураг 9. Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (стандартыг хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээний хувийн жин, стандартын шаардлага тус бүрээр)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Зураг 10. Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (стандартыг зургаас харж тодорхойлох боломжгүй төсөл, арга хэмжээний хувийн жин, стандартын шаардлага тус бүрээр)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Хүснэгт 6. Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал

№	Стандартын шаардлага	Стандартыг хэрэгжүүлсэн		Стандартыг хэсэгчлсэн хэрэгжүүлсэн		Стандартыг хэрэгжүүлээгүй		Стандартын хэрэгжилтийг зургаас тодорхойлох боломжгүй	
		Төслийн тоо	Хувь	Төслийн тоо	Хувь	Төслийн тоо	Хувь	Төслийн тоо	Хувь
1	Ажлын нэр	545	92.5%	0	0.0%	0	0.0%	44	7.5%
2	Хөрөнгийн эх үүсвэр	398	67.6%	0	0.0%	131	22.2%	60	10.2%
3	Хүчин чадал	344	58.4%	0	0.0%	185	31.4%	60	10.2%
4	Захиалагч байгууллагын нэр, утасны дугаар	5	0.8%	510	86.6%	18	3.1%	56	9.5%
5	Гүйцэтгэгч байгууллагын нэр, утасны дугаар	22	3.7%	500	84.9%	11	1.9%	56	9.5%
6	Талбайн инженерийн нэр, утасны дугаар	398	67.6%	11	1.9%	123	20.9%	57	9.7%
7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны нэр, утасны дугаар	343	58.2%	15	2.5%	174	29.5%	57	9.7%
8	Гэрээний үнийн дүн	319	54.2%	0	0.0%	209	35.5%	61	10.4%
9	Ажил эхлэх, дуусах хугацаа	481	81.7%	0	0.0%	48	8.1%	60	10.2%
10	Төсөл хэрэгжиж бий болох загвар зураг 3D/Бүтээн байгуулалтын загвар зураг	562	95.4%	0	0.0%	22	3.7%	5	0.8%
11	Дэвсгэр өнгө-Цэнхэр	416	70.6%	0	0.0%	173	29.4%	0	0.0%
12	Үсгийн өнгө-Цагаан	370	62.8%	0	0.0%	219	37.2%	0	0.0%
13	Самбарын мэдээлэл-Монгол хэл	585	99.3%	0	0.0%	0	0.0%	4	0.7%
14	Самбарын тулгуур-Металл багана	211	35.8%	0	0.0%	294	49.9%	84	14.3%
15	Самбарын байршил	546	92.7%	0	0.0%	0	0.0%	43	7.3%

Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Зураг 11. Стандартын шаардлагыг харьцангуй сайн хэрэгжүүлсэн мэдээллийн биет самбартай төсөл, арга хэмжээнүүдийн жишээнээс



Цэцэрлэгийн барилга, 150 ортой
(Архангай, Эрдэнэбулган сум, 9 дүгээр цэцэрлэг)



Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газрын
цахилгаан хангамж
(Баян-Өлгий, Цэнгэл сум) Багц 2



Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих,
240 ортой (Архангай, Эрдэнэбулган сум, 5 дугаар
цэцэрлэг)



Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын
шинэчлэл, сайжруулалт (Дорнод, Хэрлэн сум)



Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам
сүлжээний 2 дугаар ээлжийн ажил
(Төв, Эрдэнэ сум)



Сумын төвийн хатуу хучилттай авто зам
(Сүхбаатар, Асгат сум)

Мэдээллийн биет самбарын стандартын хэрэгжилт барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээнүүдийнх дунджаар 69.7 хувьтай, их засварын төсөл, арга хэмжээнүүдийнх дунджаар 56 хувьтай байна.

Төсөл, арга хэмжээ тус бүрийн мэдээллийн биет самбарын стандартын хэрэгжилтийн оноог үнэлэхдээ дараах зарчмыг баримтлав. Үүнд, тухайн стандартыг хангасан бол 1 оноо, хангаагүй бол 0 оноо, хэсэгчлэн хангасан бол 0.5 оноо өгөв. Захиалагч байгууллагын нэр, утасны дугаар, Гүйцэтгэгч байгууллагын нэр, утасны дугаар, Талбайн инженерийн нэр, утасны дугаар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны нэр, утасны дугаар гэсэн стандартын шаардлагуудын хувьд самбарт зөвхөн нэр, утасны дугаарыг аль нэгийг тавьсан тохиолдлууд байсан бөгөөд энэ тохиолдолд хэсэгчлэн хэрэгжүүлсэн гэж үзэж 0.5 оноо өгсөн болно. Төсөл хэрэгжиж бий болох загвар зураг 3D, Бүтээн байгуулалтын загвар зураг хоёрын аль нэг нь мэдээллийн самбарт байгаа бол 1 оноо өгөв. Мөн цахим хуудаст байршуулсан зарим мэдээллийн самбарын бичвэр нь стандартыг хэрэгжүүлсэн эсэх, тулгуур багана нь металл эсэх, самбарыг байршуулсан эсэхийг

зургаас харж тодорхойлох боломжгүй байлаа. Иймд тухайн стандартын хэрэгжилтийг зургаас харж тодорхойлох боломжгүй бол 0 оноо өгсөн болно. Нийт 15 стандартын шаардлага хангах буюу 15 оноо авах ёстойгоос хэдэн оноо авсан байна гэдгээр төсөл, арга хэмжээ тус бүрийн мэдээллийн биет самбарын стандартын хэрэгжилтийн оноо ба хэрэгжилтийн хувийг тодорхойлов (Хавсралт 2).

Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн 589 төсөл, арга хэмжээг төрлөөр нь авч үзвэл барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж оноо 10.46, стандартын хэрэгжилтийн дундаж хувь 69.7 хувь байна. Харин их засварын төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж оноо 8.39, стандартын хэрэгжилтийн дундаж хувь 56 хувь байна.

Хүснэгт 7. Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (төсөл, арга хэмжээний төрлөөр)

Төрөл	Төсөл, арга хэмжээний тоо	Стандартын хэрэгжилтийн дундаж оноо	Стандартын хэрэгжилтийн дундаж хувь
Барилга байгууламж	542	10.46	69.7%
Их засвар	47	8.39	56%

Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсролын сайд нарын төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 76.7–79.1 хувь байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Улсын Ерөнхий прокурорын мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 46.7–61.3 хувь байна.

Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн 589 төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсролын сайд,

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрчим хүчний сайд, Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Эрүүл мэндийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн сайд төсөл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд нарын төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 70.2-79.1 хувь байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын Захирагч нарын төсөл,

арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 60.0-61.8 хувь байна. Харин Улсын Ерөнхий прокурорын төсөл, арга хэмжээний стандартын хэрэгжилтийн дундаж хувь хамгийн бага буюу 46.7 хувь байна.

Зураг 8. Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (төсвийн ерөнхийлөн захирагчид, стандартын хэрэгжилтийн дундаж хувиар)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Хүснэгт 8. Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (төсвийн ерөнхийлөн захирагчдаар)

Төрөл	Төсөл, арга хэмжээний тоо	Стандартын хэрэгжилтийн дундаж оноо	Стандартын хэрэгжилтийн дундаж хувь
Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	11	11.9	79.1%
Хууль зүй, дотоод хэргийн сайд	6	11.8	78.3%
Боловсролын сайд	96	11.5	76.7%
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	10	11.2	74.3%
Эрчим хүчний сайд	74	11.0	73.5%
Монгол Улсын Шадар сайд	3	11.0	73.3%
Сангийн сайд	2	11.0	73.3%
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	68	10.9	72.9%
Эрүүл мэндийн сайд	24	10.9	72.4%
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	42	10.6	70.6%
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	6	10.6	70.6%
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	20	10.5	70.2%
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	5	9.2	61.3%

Төрөл	Төсөл, арга хэмжээний тоо	Стандартын хэрэгжилтийн дундаж оноо	Стандартын хэрэгжилтийн дундаж хувь
Зам, тээврийн сайд	83	9.1	60.8%
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч	138	9.0	60.0%
Улсын Ерөнхий прокурор	1	7.0	46.7%


Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудад байршилтай төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь харьцангуй өндөр байгаа бол Дорнод аймагт хамгийн бага байна.

Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн улсын төсөв, ТӨК-ийн санхүүжилтээр аймгуудад хэрэгжих төсөл, арга хэмжээг авч үзвэл Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудад байршилтай төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь хамгийн өндөр буюу 80.6-86.7 хувь байна. Булган, Дорноговь, Ховд, Орхон, Өмнөговь,

Төв, Баян-Өлгий, Хөвсгөл, Дундговь, Өвөрхангай, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад байршилтай төслүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 71-78.3 хувь, Завхан, Баянхонгор, Хэнтий, Говь-Алтай, Архангай, Увс, Дорнод аймгуудад байршилтай төслүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 63.6-69.5 хувь байна.

Зураг 9. Улсын төсөв, ТӨК-ийн санхүүжилтээр аймгуудад хэрэгжих мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (стандартын хэрэгжилтийн дундаж хувиар)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Хүснэгт 10. Улсын төсөв, ТӨК-ийн санхүүжилтээр аймгуудад хэрэгжих мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал

Аймаг	Төсөл, арга хэмжээний тоо	Стандартын хэрэгжилтийн дундаж оноо	Стандартын хэрэгжилтийн дундаж хувь
Дархан-Уул, Сэлэнгэ	1	13.0	86.7%
Говьсүмбэр	6	13.0	86.7%
Сүхбаатар	21	12.1	80.6%
Булган	14	11.8	78.3%
Дорноговь	7	11.4	76.2%
Ховд	26	11.4	75.9%
Орхон	4	11.4	75.8%
Өмнөговь	3	11.3	75.6%
Төв	19	11.3	75.4%
Баян-Өлгий	12	11.1	74.2%
Хөвсгөл	24	11.1	74.0%
Дундговь	12	11.1	73.9%
Өвөрхангай	38	10.8	71.7%
Дархан-Уул	44	10.7	71.3%
Сэлэнгэ	13	10.7	71.0%
Завхан	31	10.4	69.5%
Баянхонгор	18	10.2	68.0%
Хэнтий	28	10.2	67.7%
Говь-Алтай	10	10.1	67.0%
Баян-Өлгий, Хөвсгөл, Хэнтий	1	10.0	66.7%
Архангай	17	9.9	65.9%
Увс	19	9.7	64.7%
Дорнод	13	9.5	63.6%

Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Өмнөд, Хойд, Зүүн бүсүүдэд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарын стандартын хэрэгжилт харьцангуй доогуур байна.

Улсын төсвөөр бүсүүдэд хэрэгжих Биет мэдээллийн самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн 14 төсөл, арга хэмжээг авч үзвэл мэдээллийн самбарын стандартын

хэрэгжилтийн дундаж хувь Говийн бүсэд 93.3 хувь, Төвийн бүсэд 66.7 хувь, Баруун бүсэд 61.1 хувь, Өмнөд ба хойд бүсэд 46.7 хувь, Зүүн бүсэд 40 хувь байна.

Хүснэгт 11. Биет мэдээллийн самбарын зургийг цахим хуудаст байршуулсан улсын төсвөөр бүсүүдэд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал

Аймаг	Төсөл, арга хэмжээний тоо	Стандартын хэрэгжилтийн дундаж оноо	Стандартын хэрэгжилтийн дундаж хувь
Говийн бүс	1	14.0	93.3%
Төвийн бүс	6	10.0	66.7%
Хангайн бүс	1	9.5	63.3%
Баруун бүс	3	9.2	61.1%
Өмнөд бүс	1	7.0	46.7%
Хойд бүс	1	7.0	46.7%
Зүүн бүс	1	6.0	40.0%


Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Нийслэлийн дүүргүүдэд байршилтай төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 59–70 хувь байна.

Улс, нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан төсөл, арга хэмжээг дүүргүүдээр авч үзвэл мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь Чингэлтэй, Багахангай дүүргүүдэд 70 хувь,

Сонгинохайрхан дүүрэгт 66.8 хувь, Налайх дүүрэгт 66.7 хувь, Баянзүрх дүүрэгт 66.4 хувь, Багануур дүүрэгт 62.7 хувь, Хан-Уул дүүрэгт 60.1 хувь, Баянгол дүүрэгт 59.7 хувь, Сүхбаатар дүүрэгт 59 хувь байна.

Зураг 10. Улс, нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (дүүргүүдээр, стандартын хэрэгжилтийн дундаж хувиар)



Эх сурвалж: publicinvestment.gov.mn

Хүснэгт 12. Улс, нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих бөгөөд мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст байршуулсан төсөл, арга хэмжээнүүд мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн байдал (дүүргүүдээр)

Аймаг	Төсөл, арга хэмжээний тоо	Стандартын хэрэгжилтийн дундаж оноо	Стандартын хэрэгжилтийн дундаж хувь
Чингэлтэй дүүрэг	11	10.5	70.0%
Багахангай дүүрэг	2	10.5	70.0%
Сонгинохайрхан дүүрэг	22	10.0	66.8%
Налайх дүүрэг	3	10.0	66.7%
Баянзүрх дүүрэг	27	10.0	66.4%
Багануур дүүрэг	11	9.4	62.7%
Нийслэл	38	9.3	61.8%
Хан-Уул дүүрэг	23	9.0	60.1%
Баянгол дүүрэг	34	9.0	59.7%
Сүхбаатар дүүрэг	23	8.8	59.0%

Эх сурвалж: publicinvestment.gov.mn

ТОЙМ ДҮГНЭЛТ

Улс, нийслэлийн төсөв ба төрийн өмчит компанийн санхүүжилттэй хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэгч нь мэдээллийн самбарын стандартыг хэрэгжүүлсэн эсэхийг publicinvestment.gov.mn цахим хуудаст самбарын зургаа нийтэлсэн байдал дээр үндэслэн судалсан энэхүү дүн шинжилгээний хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна:

- Судалгаанд хамрагдсан улс, нийслэлийн төсвийн санхүүжилттэй 1011 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 58.3 хувь буюу 589 нь мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлжээ. Харин 41.7 хувь буюу 422 төсөл, арга хэмжээ мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтлээгүй байна. Эдгээр төсөл, арга хэмжээ нь мэдээллийн самбарын хэвлэгдээгүй загвар зураг, эсвэл word, power point зэрэг дээр бэлдсэн төсөл, арга хэмжээний талаарх мэдээлэл, самбар дээр гараар бичсэн мэдээлэл, QR код, барилгын зураг, ажлын явцын зураг, аюулгүй байдлын санамж, төсөв, тайлан, гэрээ, акт, албан бичгүүд зэрэг бусад мэдээллийн зургийг цахим хуудаст нийтэлжээ.
- Төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст

нийтэлсэн байдлын гүйцэтгэлийн хувийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл Монгол Улсын Шадар сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Эрчим хүчний сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд нарын гүйцэтгэл 70-аас дээш хувь байна. Харин Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын гүйцэтгэл 0 хувь байна.

- Улсын төсөв, ТӨК-ийн санхүүжилтээр аймгуудад хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлыг авч үзвэл Орхон, Баянхонгор, Дархан-Уул, Өвөрхангай, Өвөрхангай, Дундговь аймгуудын гүйцэтгэл 80-аас дээш хувь байгаа бол Дундговь аймагт 46.7 хувь буюу хамгийн муу гүйцэтгэлтэй байна.
- Улс ба нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих төсөл, арга хэмжээний мэдээллийн биет самбарын зургийг цахим

хуудаст нийтэлсэн байдлыг дүүргүүдээр авч үзвэл Багануур дүүрэг хамгийн өндөр буюу 64.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол Багахангай дүүрэг 25 хувь буюу хамгийн муу гүйцэтгэлтэй байна.

Мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн 589 төсөл, арга хэмжээний хувьд:

- Самбарын тулгуур нь металл багана байх, үсгийн өнгө цагаан байх, хүчин чадал ба гэрээний үнийн дүнг тусгах гэсэн стандартуудын хэрэгжилт харьцангуй сул байна.
- Мэдээллийн самбарын стандартын хэрэгжилт барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээнүүдийнх дунджаар 69.7 хувьтай, их засварын төсөл, арга хэмжээнүүдийнх дунджаар 56 хувьтай байна.
- Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрчим хүчний сайд, Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Эрүүл мэндийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Хүнс, хөдөө

аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд төсөл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд нарын төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 70.2-79.1 хувь байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь 60.0-61.8 хувь байна. Харин Улсын Ерөнхий прокурорын төсөл, арга хэмжээний стандартын хэрэгжилтийн дундаж хувь хамгийн бага буюу 46.7 хувь байна.

- Улсын төсөв, ТӨК-ийн санхүүжилтээр аймгуудад хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн хувьд Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудад байршилтай төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь харьцангуй өндөр байгаа бол Дорнод аймагт байршилтай төслүүдийнх хамгийн бага байна.
- Улс ба нийслэлийн төсвөөр нийслэлд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн хувьд мэдээллийн самбарын стандартын хэрэгжилтийн дундаж хувь дүүргүүдэд 59-70 хувь байна.

ЗӨВЛӨМЖ

Улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага бүхий Үндэсний MNS 7023 2023 стандартыг улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч этгээд хэрэгжүүлж буй эсэхэд хийсэн дүн шинжилгээний дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг дэвшүүлж байна:

- Төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдал хангалтгүй байгаа тул

стандартын хэрэгжилтийг хангуулах ажлыг төсвийн ерөнхийлөн захирагчид анхаарах, хэрэгжилтэд хяналт тавих;

- Цахим хуудаст зураг нь нийтлэгдсэн мэдээллийн биет самбаруудын хувьд стандартын хэрэгжилт хангалтгүй байгаа тул стандартын шаардлагын биелэлтийг хангуулах чиглэлээр оролцогч талуудад заавар өгөх, сургалт зохион байгуулах;
- Төсөл, арга хэмжээнүүдийн мэдээллийн биет самбарын зургийг цахим хуудаст нийтэлсэн байдлыг тогтмол хянаж, гүйцэтгэлийг нэгтгэн олон нийтэд ил тод мэдээлдэг тогтолцоо бүрдүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн <https://publicinvestment.gov.mn/> хуудас
- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023.12.01-ний өдрийн С/49 дүгээр тушаалаар батлагдсан улс, орон нутаг, гадаадын зээл, тусламжаар санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага бүхий Үндэсний MNS 7023 2023 стандарт
- Монгол Улсын төсвийн тухай хуулиуд

ХАВСРАЛТ 1. МЭДЭЭЛЛИЙН БИЕТ САМБАРЫН ЗУРГИЙГ ЦАХИМ ХУУДАСТ БАЙРШУУЛААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД

№	Төслийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсвийн ерөнхийлөн захирагч	Цахим хуудаст байршуулсан мэдээлэл
1	УТ2401300882001	Багц-1 "Өгий нуурын урсацыг сайжруулах, оролтыг нэмэгдүүлэх ажил"	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Самбар байрлуулсан тухай
2	УТ2401300825014	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/-Цаг уурын өртөөний барилгын шинэчлэл /Булган, Сэлэнгэ, Ингэт толгой/	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Загвар зураг
3	УТ2501300829006	Зүүн бүсэд Ус, Цаг уур, Хамгаалалтын захиргааны харуулын байр барих (Дорнод, Сүхбаатар, Хэнтий)	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Хүсэлт гаргах тухай албан бичиг
4	УТ2401300389003	Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2-р үе шат /Сүхбаатар/Багц-3 "Хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, ойн төгөл, байгуулах " ажил	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Хүсэлт
5	УТ2401300389002	Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2-р үе шат /Сүхбаатар/ Багц -2 "Ганга нуурын бохирдолт,ширгэлтээс хамгаалах" ажил	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Барилгын ажлын явц
6	УТ2401300389001	Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2-р үе шат /Сүхбаатар/ Багц-01 "Газрын доорх усны эх үүсвэрийг сэргээхэд хийж гүйцэтгэх" ажил	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Хэвлэмэл баримт бичгүүд
7	УТ2501300829008	Төвийн бүсэд Ус, Цаг уур, Хамгаалалтын захиргааны харуулын байр барих (Өвөрхангай, Сэлэнгэ, Дархан, Төв, УБ)	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Барилгын зураг
8	УТ2501300845007	Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17-р бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалт /УБ/Багц 5 "COP 17 хурлын байр, байгууламжийн гадна гэрэлтүүлгийн кабель болон хамгаалалтын хоолойн угсралтын ажил /УБ хот/"	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Веб screen shot
9	УТ2501300845004004	Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17-р бага хурлыг зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалт /УБ/Багц 5 "COP 17 хурлын байр, байгууламжийн гадна гэрэлтүүлгийн кабель болон хамгаалалтын хоолойн угсралтын ажил /УБ хот/"	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Зураг төслийн зураг
10	УТ2501300826005	Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17-р бага хурлын байгууламж /УБ/ Багц 5 "Гадна холбоо /УБ хот/"	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Самбар дээр гараар бичсэн

№	Төслийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсвийн ерөнхийлөн захирагч	Цахим хуудаст байршуулсан мэдээлэл
11	УТ2501300826001	Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17-р бага хурлын байгууламж /УБ/ Багц 1 "Загвар зураг төсөв боловсруулах ажил /УБ/"	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Зураг төсөв
12	УТ2501300289023	Усны газрын барилгын дотор дулаан хангамж цэвэр усны шугам солих, ариун цэврийн өрөөний засварын ажлын /УБ хот, БГД/	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Барилгын зураг
13	УТ2501300289001	Засгийн газрын 12-р байрны их засвар	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Барилгын зураг
14	УТ2501300289007	Увс нуурын ай савын УТХГ-ын гадна фасадын их засвар /Увс аймаг, Улаангом сум/	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Барилгын зураг
15	УТ2401300825009	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/-Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Горхи Тэрэлжийн БЦГ/	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Барилгын зураг
16	УТ2501300222006	Дөргөний хөв цөөрөм /Ховд, Дөргөн/	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Аюулгүй байдлын санамж
17	УТ2401300882002	Багц-2 "Өгий нуурыг бохирдолт, ширгэлтээс хамгаалах ажил"	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	Хоосон самбар
18	УТ2401502377	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 8-р цэцэрлэг/	Боловсролын сайд	Word файл дээр бичсэн мэдээлэл
19	УТ2401502376	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 3-р цэцэрлэг/	Боловсролын сайд	Барилгын ажлын явц
20	УТ2401502375	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 14-р цэцэрлэг/	Боловсролын сайд	Зураг төсөл хүлээлцсэн акт
21	УТ2401502374	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өлзийт сум/	Боловсролын сайд	Барилгын ажлын явц
22	УТ2401501686	Дотуур байрны барилга, 100 ор /Архангай, Төвшрүүлэх сум/	Боловсролын сайд	Барилгын ажлын явц
23	УТ2001500566	Сургуулийн барилгын өргөтгөл /Архангай, Өлзийт сум/	Боловсролын сайд	Самбар дээр гараар бичсэн
